

Боловсрол, шинжлэх ухааны яам

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны
тайлан

Улаанбаатар хот
2020 он

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

- 1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал
- 1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох
- 1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУД

- 4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- 4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
- 4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө
- 4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- 4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН¹

*Боловсролын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын талаар*

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 803 сургуульд 600,3 мянган (өдрөөр 593,150, оройгоор 108, эчнээгээр 219, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр 6,917) суралцагч, 30.4 мянган багш ажиллаж байна. Ерөнхий боловсролын нийт сургуулийн 81.7 хувь нь төрийн өмчийн, 18.3 хувь нь хувийн сургууль байх бөгөөд өдрөөр суралцагчдын 93.3 хувь (553.5 мянга) нь төрийн өмчийн, 6.7 хувь (39.5 мянга) нь хувийн сургуульд тус тус суралцаж байна. Харин багш нарын 90.8 хувь (27.6 мянга) нь төрийн, 9.2 хувь (2.7 мянга) нь хувийн өмчийн сургуульд ажиллаж байна.

Мөн боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага болох Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын үндэсний төв нь бага, дунд боловсролын агуулга, хөтөлбөр, арга зүй, үнэлгээг хөгжүүлэх судалгаа хийх, бодлогын хувилбар боловсруулах, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, хүн амын боловсролын түвшнийг ахиулах, иргэн боловсролоо ахиулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиглэлээр орон нутгийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж байна.

Иргэдийн ерөнхий боловсрол эзэмшихтэй холбогдон үүсэх харилцааг Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого болон захиргааны хэм хэмжээ тогтоосон 57 акт буюу дүрэм, журмаар зохицуулж байна. Хэдийгээр захиргааны хэм хэмжээ тогтоох актад заагдаагүй ч салбарын хэмжээнд зохицуулалт зайлшгүй шаардсан зарим харилцааг зохицуулах дүрэм, журмыг хуульд нийцүүлэн батлан мөрдөж байна. Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай зэрэг хууль тогтоомжоор ерөнхий боловсролын харилцаанд оролцогчид түүний дотор сургууль, багш нарын дагаж мөрдөх хэм хэмжээг заасан.

Нийгмийн харилцааны хөгжил, хурдацтай өөрчлөгдөж буй улс орны нийгэм, эдийн засгийн байдалтай уялдуулан боловсролын салбарын хууль, эрх зүйн хүрээнд дахин нягталж зохицуулах шаардлагатай тодорхой асуудлууд байна.

Хэдийгээр нийгмийн зүгээс хуульд өөрчлөлт оруулах давтамж, хугацааг хууль тогтвортой үйлчилж байх зарчмын үүднээс шүүмжлэх хандлага байдаг ч хуулийн хэрэгжилт, үр нөлөөг нэмэгдүүлэх, алдаа дутагдлыг засаж сайжруулах, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, боловсролын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, хууль хэрэгжих явцад практикт үүсэж буй зохицуулалт шаардлагатай харилцааны хэм хэмжээг хуульчлах, хүчин төгөлдөр үйлчилж байгаа

¹Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд тулгамдсан зарим асуудлын хүрээнд боловсруулав.

хуулийн зарим зохицуулалтыг илүү тодорхой, нийтэд ойлгомжтой байдлаар зохицуулах хэрэгцээ, шаардлага байгаа юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 58-д “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасны дагуу холбогдох хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Судалгааны аргачлал:

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу дараах үе шатаар хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

Дээрх дарааллын дагуу нэгдүгээрт “Боловсролын тухай хууль”-д үүсэж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Үүний тулд боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, тэдгээрийн холбогдох мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач, иргэдээс судалгаа авах, боловсролын салбарт хийгдсэн уулзалт хэлэлцүүлэг, хурал, зөвлөгөөнөөс гарсан санал, зөвлөмж, холбогдох бусад статистик мэдээлэл зэргийг ашигласан бөгөөд асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг бусад этгээд болон тухайн асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тус тус тодорхойлов.

Асуудлыг тодорхойлсны дараагаар асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгоо томъёолж, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Тухайн үе шатанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч үр нөлөөг судалсан.

Эцэст нь тухайн судалгааны хувилбаруудаас сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал²/цаашид “Аргачлал” гэх/-ын 2.1 дэх хэсэгт заасан үе шатын дагуу хийж гүйцэтгэв.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Манай орны хувьд Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2002 онд батлагдсанаас хойш нийт 25 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Боловсролын тухай хууль 7 бүлэг 48 зүйлтэй бөгөөд боловсролын зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулж байна.

Энэхүү хууль хэрэгжээд 16 жил болж байгаа боловч зарим зохицуулалтыг нийгмийн эрэлт шаардлагад нийцүүлэн дахин нягталж боловсронгуй болгох, боловсролын хөгжлийн шаардлагаар нийгэмд шинээр үүсэж буй эрэлт хэрэгцээнд тохируулахад чиглэсэн хөгжлийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх зохицуулалт бий болгох, хуулийн хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх, зарим харилцааны зохицуулалт тодорхой бус, орхигдсон тул тэдгээр харилцааны хийдэл, зөрчлийг арилгах шаардлага тавигдаж байна.

Иймд аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа боловсролын сургалтын байгууллага, иргэн, бусад этгээдийг тодорхойлж, түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Дээр дурдсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд голлон анхаарал татаж байна. Үүнд:

“Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан 2017”-д Монгол Улс 63 улсаас 62-рт эрэмбэлэгдсэн байна. Дээд боловсролын сургалтын байгууллагууд, түүний дотор магадлан итгэмжлэгдсэн 67 их дээд сургуулиуд үйл ажил ажиллагаа явуулж боловч төгсөгчдийн дөнгөж 40% нь сурсан мэргэжилтэйгээ холбоотой ажил хөдөлмөр эрхэлж байна. Удаа дараагийн судалгааны дүнд төгсөгчдийн ажил эрхэлж чадахгүй байгаагийн нэг шалтгааныг “Мэргэжлийн төвшин, ур чадвар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахгүй байна” гэсэн дүгнэлт гарчээ.

ЮНЕСКО-гоос гаргасан “Боловсролын талаар дахин эргэцүүлэн бодох нь” хэмээх номд “Дэлхий ертөнцийг өөрчлөлтийг даган боловсрол бас өөрчлөгдөх ёстой. Нийгмийн бүх салбарт гүн гүнзгий өөрчлөлт гарч байгаа учраас нийгэм, эдийн засагт өнөөдөр тэр тусмаа хэрэгтэй байгаа ур чадвар, чадамжийг хөхиүлэн дэмждэг боловсролын шинэ хэлбэр шаардагдаж байна” хэмээн бичжээ.

²Монгол Улсын газрын 2016 оны Засгийн 59 дүгээр тогтоол. Нэгдүгээр хавсралт.

Мөн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хурдац нь шинээр гарч ирэх мэргэжил, түүнтэй холбоотой ур чадваруудыг урьдчилан таамаглах ажлыг хүндрэлтэй болгож байна. Энэ илүү уян хатан боловсролын системийг бий болгох, хурдацтай өөрчлөгдөж буй хэрэгцээ, шаардлагад мэргэжлийн мэдлэгийг хэрэглэх тал бүрийн ерөнхий дадал чадварыг хөгжүүлэхэд түлхэц болох, ажилтан хүн гаднын нөхцөл байдалд илүү уян хатан зохицох, өөрийгөө үр дүнтэй чадвартай, тодорхой мэргэжлийн ажилд шаардлагатай мэргэшлийн ур чадварыг амьдралд хэрэгжүүлэх чадвартай байхыг шаардана гэж үзэж байна.

Манай орны хувьд бусад улс орны боловсролын хөгжлийн туршлагыг судалж турших, өөрийн нөхцөлд тохируулан нутагшуулах замаар дээд боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх нь хөгжлийн нэн тулгамдсан шаардлага болж байна.

ХНХЯ-наас 2016 онд гаргасан судалгаагаар дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт сүүлийн 4 жилд 74,4-80.5% гэсэн судалгаа гарчээ. Тэгвэл 2017 оны ажиллах хүчний эрэлт хэрэгцээний талаарх судалгаагаар шинэ ажлын байр 43000, сул ажлын байр 27600, нийт 70600 ажлын байр хэрэгцээтэй байгааг илрүүлжээ.

Бакалавр, магистрант, докторантад суралцагчдын тооны харьцаа 1:6 байгаа нь сургалтын байгууллагууд бакалаврын сургалтад тулгуурлаж үйл ажиллагаа явуулж байгааг харуулж байна. Үүнийг цаашид өөрчлөн дээд боловсролын сургалтын байгууллагуудад төгсөлтийн дараах сургуулиудад ахисан түвшинд суралцагчдын тоог нэмэгдүүлэх, элсэлтийн бодлогод тэнцвэртэй харьцаа бий болгох, сургалтын чанарт болон шинжлэх ухааны салбар чиглэлээр төрөлжүүлэн сургалт-судалгаа, эрдэм шинжилгээ, инновацийн ажилд төвлөрч үйл ажиллагаа явуулах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дээд боловсролын салбарын нийт хүний нөөцийн 68.0 хувийг сургалтын байгууллагын үндсэн чиг үүргийг гүйцэтгэх, үлдсэн 32.0 хувийг бусад ажилтан, ажилчид бүрдүүлж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагуудад ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан, эрдэм шинжилгээний туслах ажилтнуудын эзлэх хувь маш бага байгаа нь цаашид судалгаанд суурилсан их сургуулийг бий болгох, хүний нөөцийг хөгжүүлэхэд анхаарах гол асуудлуудын нэг юм.

Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад хувийн болон төрийн бус байгууллагын зардлаар суралцагчдын нэгдсэн мэдээлэл, бүртгэлд хамруулах зохицуулалт шаардлагатай байна.

Сонгодог урлагийн чиглэлээр дээд боловсрол эзэмшүүлэхтэй холбоотой зардлыг төр хариуцаж, дэмжих хөгжих бололцоог нэмэгдүүлэх, олон улсад дотоодын сургуулийн нэр хүнд өсгөх хэрэгцээтэй байна.

Магадлан итгэмжлэлийг олон улсын жишигт нийцүүлэх дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын дотоод баталгаажуулалтыг үр нөлөөг сайжруулах, хөтөлбөрийг үр дүнг үнэлэх явцыг сайжруулах хэрэгцээ үүсэж байна.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод суралцагчдад үр бүтээлтэй хөдөлмөрлөж, тогтвортой сайхан амьдрахад нь шаардагдах мэдлэг, чадвар чадамжийг эзэмшүүлэх, зөв хандлага төлөвшилтэй болгох, насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхээр зорьж байна.

Иймд дээд боловсролын сургалтын байгууллагын үр дүн, чанарыг сайжруулах суралцагчдыг мэдлэг, ур чадвар, хандлагыг хөгжүүлэх нь улс орны хөгжил, иргэдийн амьдралын баталгааг хангах нэн тэргүүний асуудал болоод байна.

Мөн Боловсролын тухай хуулийн зарим зүйл, заалтыг хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинээр авч үзэх, боловсролын үйл ажиллагааны тогтвортой нөхцөлийг хангаж бодлогын залгамж чанарыг хадгалах асуудлыг тусгах замаар хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;

Боловсролын байгууллагын удирдлага, үйл ажиллагааг улс төрөөс ангид байлгах, боловсролыг тогтворшуулан хөгжүүлэх нөхцөлийг хангах, багш болон бусад ажилтны хөгжил, нийгмийн баталгааг адил тэгш хангах, мэргэжлийн байгууллагад суурилсан мэргэшсэн боловсролын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, сургууль бүр өөрийн онцлог, нөхцөл бололцоонд зохицон бие даан хөгжих эрхийг өргөжүүлэх, суралцагчийн сурч боловсрох эрхийг тэгш хангах, сургууль, эцэг, эх, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, боловсролын байгууллагын орчин дахь аюулгүй байдлыг хангахтай холбогдох харилцааг хуулийн хүрээнд илүү тодорхой байдлаар зохицуулах;

Хууль хэрэгжих хугацаанд практикт үүсээд буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэх, хуулийн зохицуулалтгүй эсвэл зохицуулалт тодорхой бус байдлын улмаас сургууль, багш, суралцагч, иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэдэг асуудлыг нийтэд ойлгомжтой болгох зорилгоор холбогдох өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 04-ний өдрүүдэд Улаанбаатар хот, Дорнод, Өвөрхангай, Ховд, Орхон аймагт бүсчлэн зохион байгуулсан “Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол” улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогч ерөнхий боловсролын сургуулийн нийт багш, удирдах ажилтны 10.0 хувь болох 3400 төлөөлөгчдөөс гаргасан зөвлөмж, зөвлөгөөний www.zuvluguun.edu.mn вэб хуудсаар багш, ажилтнуудаас ирүүлсэн саналуудыг тус тус судалж үзсэн болно.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох³

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар энэхүү хуулийн хүрээнд эрх ашиг нь хөндөгдөж байгаа аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, дүүргийн боловсролын хэлтсийн дарга болон ерөнхий боловсролын сургуулийн захирал, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага болох Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын төв, өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, түүний багш, ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогч иргэн, аж ахуйн нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсэхгүй бөгөөд харин эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгосноор боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмж дээшилж, боловсролын

³ Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа.

байгууллага, удирдлагын үйл ажиллагааны тогтвортой байдал хангагдах, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцөл сайжирна.

Боловсролын тухай хууль нь шууд болон шууд бус утгаар Монгол Улсын боловсролын салбарын хөгжил, мэдлэг боловсролтой иргэнийг төлөвшүүлэх, хөдөлмөрийн зах зээлд чанартай хүний нөөцийг бэлтгэхэд нөлөөлөх чухал асуудал юм.

1.3 Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Холбогдох мэдээллийг харьцуулан үзэхэд Боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн явцад зохицуулалт нь тодорхой бус, зохицуулалт шаардсан шийдвэл зохих дараах асуудлууд байсаар байна:

1. Нийгмийн суурь харилцаа зохицуулдаг хууль (Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль гэх мэт)-иудыг дагаж салбарын хуулиудад өөрчлөлт орж байгаа нь салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас үл хамаарч тухайн хуулийн бүтэц, агуулгад нөлөөлөх, мөн хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн баримт бичиг 4 жилийн давтамжтай шинэчлэгдэж, түүнд нийцүүлэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хандлага тус тус ажиглагдаж байна. Энэ нь салбарын хууль, эрх зүй, бодлогын тогтвортой байдлыг хангахад сөргөөр нөлөөлж байна.

2. Хууль хэрэгжих явцад практикт үүсэж буй зөрчил, бэрхшээлүүд, тухайлбал, хүчин төгөлдөр үйлчилж буй Боловсролын тухай хуулийн 28.1.12, 30.1.11, 30.1.15-т заасны дагуу удирдах ажилтныг сонгон шалгаруулалтын зарчмаар томилох хуультай хэдий ч ажлын туршлага, үр дүн, мэргэшсэн байдлыг үл харгалзан томилох эрх бүхий этгээд солигдох бүрт удирдах ажилтан өөрчлөгдөх тохиолдол сүүлийн жилүүдэд гарах болсон. Энэ нь төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчим алдагдаж, түүнээс үүдэн төсвийн үр ашиггүй байдал үүсэхэд хүргэж байна. Жишээ нь, 2012 оны УИХ болон орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнгээр аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарын 86.3 хувь, дүүргийн боловсролын хэлтсийн дарга нар 100 хувь чөлөөлөгдсөн бол 2016 оны сонгуулийн үр дүнгээр аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарын 77.2 хувь, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн дарга нарын 87.5 хувь нь тус тус чөлөөлөгдсөн байна. Мөн хууль бусаар ажлаас халагдсан гэх үндэслэлээр ерөнхий боловсролын лаборатори сургуулийн 6 захирал захиргааны хэргийн шүүхэд хандаж, шүүхээс буцаан томилох шийдвэр гарсан байна. Энэхүү байдал нь аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн томилгоо нь улс төрийн нам, бүлэглэлүүд дэмжигчдийгээ төрийн албан тушаалаар шагнаж урамшуулдаг асуудал практикт 4 жил тутам гарч байгаа болохыг харуулж байна.

Түүнчлэн орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн нэгжийн удирдах ажилтан болон ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд тавих шаардлага, шалгуур /туршлага, мэргэшил, ур чадвар/-ыг ажил олгогч ажлын байрны тодорхойлолтод тусган баталж байгаа. Гэвч тухайн албан тушаалд тавигдах шаардлага, шалгуурыг ажил олгогч тухайн нэр дэвшигчийн мэргэжил, туршлага, ур чадварт нийцүүлэн баталж байгаагаас удирдах түвшин дэх боловсон хүчний бодлогод улс төржих хандлага хэвээр байна. Энэ нь боловсролын байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал, залгамж чанарыг алдагдуулахыг зэрэгцээ удирдах ажилтны тогтвортой чадавх бий болоход саад болж байна.

3. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуульд удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй хэдий ч бодит байдалд энэ байгууллагын төрийн захиргааны үүрэг хэт давамгайлж, мэргэжил, арга

зүйн удирдлага алдагдах болсон. Мөн боловсролын газрын зарим мэргэжилтнүүд мэдлэг, боловсрол, ур чадвараар сургууль, багш нарт хүлээн зөвшөөрөгдөхгүй байх тохиолдол гарч байгаа талаар 2018 оны 1, 2 дугаар сард 5 бүсэд зохион байгуулсан “Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол” улсын зөвлөгөөнд оролцогчид илэрхийлж, түүний шалтгааныг мэдлэг, боловсрол, ур чадвар сайтай багш мэргэжилтнээр очиж ажиллахад цалин буурдаг, тухайн хичээл судлагдахууны чиглэлээр дагнан ажиллахгүй захиргааны ажилд ихээхэн цагаа зарцуулдаг гэж тайлбарласан.

4.Эрх зүйн зохицуулалтгүй байдлаас шалтгаалж иргэдэд ойлгомжгүй, хэрхэн шийдвэрлэх нь маргаантай нөхцөл байдал үүсэх тохиолдлууд гарч байна. Жишээ нь: Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар “Боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн ...Албан сургалт нь өдөр, орой, эчнээ, экстернат зэрэг хэлбэртэй байж болно” гэсэн өгүүлбэрийг хасаж, Дээд боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалтыг үндсэн болон цагаар гэсэн хэлбэрээр зохион байгуулна” гэж хуульчилж, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн боловсрол эзэмших хэлбэрийг орхигдуулан зохицуулалтгүй болгосон. Гэтэл Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсэгт “Орой, эчнээ, албан бус хэлбэрээр иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байх бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллээр ерөнхий боловсролын 26 сургууль орой, эчнээ анги, бүлэг хичээллүүлж, оройн ангид 108, эчнээ хэлбэрийн сургалтад 219 суралцагч тус тус суралцаж байна. Дээрх байдал нь Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна” гэсэн зарчим алдагдахад хүргэж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон сургалтын хэлбэр хуульчлагдаагүйгээс эдгээр хүүхдүүд тусгай хэрэгцээт боловсролын олон хэлбэрээс сонгож суралцах боломж хязгаарлагдмал байна.

6. Монгол Улсын Ерөнхий прокуророос Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд /хуучнаар/ хандаж 2017 оны 08 дугаар сард албан бичгээр ирүүлсэн мэдэгдэлд 2012-2016 онд “...сургуулийн насны хүүхдийн дунд амиа хорлосон 257 тохиолдол бүртгэгдсэн, өсвөр насны хүүхдийг ойлгох, сэтгэл зүйн хямрал, гутрал, тогтворгүй байдлыг даван туулахад чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ болон уг эмгэнэлт тохиолдлоос суралцагчдыг урьдчилан сэргийлэх ажлыг боловсрол, сургалтын байгууллага үзүүлдэггүй, бусдыг амиа хорлох явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатны сургалтын байгууллага зохион байгуулах, сургуулийн орчинд сурагч, оюутан сэтгэл зүйн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй болох”-ыг дурдсан байна. Түүнчлэн Авлигатай тэмцэх газарт ирж буй нийтийн албан тушаалтнуудын авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн дийлэнх хувийг боловсролын салбар дахь хээл хахууль, хууль бус төлбөр, хураамж, хандивтай холбоотой асуудлууд эзэлдэг бөгөөд Боловсролын тухай хуулийн 40.7-д заасан “...хуульд заагаагүй төлбөр, хураамж...” гэсний ойлголтыг хууль тогтоомжийн хүрээнд тодорхой болгохыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас холбогдох хууль хяналтын байгууллагаас шаардаж байгаа.

7. Сурагчдын хөгжил, төлөвшилд багшийн адил үүрэг гүйцэтгэдэг зарим ажилтнууд тухайлбал сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, насан туршийн болон албан бус боловсролын багшийн ээлжийн амралтын хоногийн хугацаа бусад багш нараас цөөн, ерөнхий боловсролын сургуулийн бусад багш нарын нэгэн

адил тэтгэвэр, тэтгэмжид адил тэгш хамрагдах эрх үүсээгүй ялгаатай хандаж байгаагаа засаж залруулах нь зүйтэй хэмээн “Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол” улсын зөвлөгөөний үеэр багш, ажилтнууд онцолж байсан. Мөн УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос 2018 оны 04 дүгээр сард зохион байгуулсан “Боловсролын хөгжил, шинэчлэлд төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын оролцоо” сэдэвт хэлэлцүүлэгт оролцогчдоос хувийн сургуулийн багш нарт өндөр насны тэтгэвэрт гарахад төрөөс тэтгэмж олгох зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах гэж үзсэн байна.

8. Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хөндлөнгийн, хараат бус хяналт тавих зохицуулалт Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар тодорхой бус болсон.

9. Эцэг, эх, асран хамгаалагчид хүүхэдтэйгээ ажиллах үүргээ орхигдуулах, цагийн боломжгүй зэргээс хамааран хараа хяналтгүй орхих, хичээл, сургалт, хүмүүжил, төлөвшилд анхаарал хандуулж чадаагүйгээс хүүхэд гэмт хэргийн золиос болох, аливаа хорт зуршилд автах зэрэг тохиолдол гарч байгаа талаар хууль хяналтын байгууллагаас мэдээлж байна. Энэхүү нөхцөл байдалтай уялдуулан нэг талаас эцэг, эх, асран хамгаалагчийн хүүхдийнхээ хүмүүжил, төлөвшил, боловсрол, хөгжлийн талаар хүлээх үүрэг, хариуцлагыг илүү нарийвчлах, нөгөө талаас аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтан, албан хаагчид хүүхэдтэйгээ ажиллах цагийн боломжийг олгох зохицуулалт бий болгох хэрэгцээ үүсэж байна.

10. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид чанартай боловсрол эзэмших эрхээ бүрэн эдэлж чадахгүй байгаа, багш-сурагчдын хоорондын харилцаа, үл ойлголцол зэргээс үүдэн хичээл хаялт зохион байгуулж, сургуулийн орчинд эмх замбараагүй байдал үүсгэсэн 2 тохиолдол 2017 онд гарсан. Гэтэл энэ төрлийн үйл ажиллагаа зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид байхгүй байна.

11. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн сургалтын үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, үнэлэх, баталгаажуулах нэгдсэн тогтолцоо буюу мэргэшлийн үндэсний хүрээ бусад орнуудын жишгээр байхгүй байна. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын статус тодорхойгүй байна. 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр БМИҮЗ-ийн хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зохицуулалт хангалтгүй.

12. Манай их, дээд сургуулийн сургалтын чанарын асуудал сүүлийн жилүүдэд асар их шүүмжлэл дагуулж байна. Нэгд, их, дээд сургууль төгсөгчдийн ажил эрхлэлт доогуур, дээд боловсролын дипломтой жолооч, худалдагч олширсоор гэсэн шүүмжлэл байна. Хоёрт, манай их, дээд сургуулиудын сургалтын арга барил шинэчлэгдэж чадахгүй байна. Гол төлөв доод эрэмбийн ур чадвар олгоход чиглэж байгаа нь сэтгэн бодох, зохион бүтээх авьяас чадварыг хөгжүүлэх дээд эрэмбийн танин мэдэхүйн арга барилыг эзэмшүүлэхэд ихээхэн дутагдал байна гэж дүгнэхэд хүргэж байна. Мөн сургалтын арга барил нь хоцрогдсон, агуулгад түшиглэсэн байдлаар гол төлөв лекцийн хичээл давамгайлсан хэлбэрээр явагдаж байгаа нь оюутан залуучуудад бодитой мэдлэг, ур чадвар олгож чадахгүй байна.

Үүнээс гадна их, дээд сургууль төгсөгчид нь харилцааны соёл сайн эзэмшээгүй, бичгийн соёл тааруу, гадаад хэлний мэдлэг дорой, нийгмийн хариуцлага, сул өөрөөр хэлбэл 21-р зууны ур чадварыг бүрэн эзэмшиж чадахгүй байгаа нь их дээд сургуулиуд

орчин үеийн “зөөлөн ур чадвар”-ыг эзэмшүүлж, төлөвшүүлэх талаар хангалтгүй ажиллаж байгаатай холбоотой.

13. Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллагын оролцоо сул, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн байгууллагуудтай уялдаа холбоо, түншлэл хангалтгүй байна. Гадаад улсад суралцагч, төгсөгчийн нэгдсэн мэдээлэл, холбоо тогтоох боломжгүйгээс дотоодын төрийн байгууллага, хувийн хэвшлийн тэргүүлэгч аж ахуйн нэгж байгууллагыг чанартай хүний нөөцөөр хангах бололцоо хомс байна. Төрийн өмчийн сургуулийн захирлыг томилоход улс төр нөлөөлж байна.

Дээрх бүхнээс дүгнэн үзэхэд Боловсролын тухай хуулийг цаашид боловсронгуй болгох, үзэл баримтлалаа тогтоож хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь боловсролын байгууллагын удирдлага, үйл ажиллагааг улс төрөөс ангид, тогтвортой байлгах, боловсролыг тогтворшуулан хөгжүүлэх нөхцөлийг хангах, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж түүний үр дүн, сурлагын чанар, төгсөгчдийн ажил эрхлэлт, ажил олгогчийн эрэлт хэрэгцээ цаашдын төлөв байдлыг харгалзан олгоход эрх зүйн орчныг боловсронгуй болгох, боловсролыг тогтворшуулан хөгжүүлэх нөхцөлийг хангах, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон цаашдын эрэлтэд нийцсэн мэргэжилтэн бэлдэх, практикт үүсэж буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэх замаар практикт үүсэж буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэх, хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгахад оршино.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Боловсролын үйлчилгээний тогтвортой, мэргэшсэн байдал болон хууль тогтоомжийн уялдааг хангах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн бэрхшээл хэвээр үлдэж, зорилгод хүрэх боломжгүй.	Сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг

2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд хууль тогтоомж хоорондын давхардал хийдэл, зөрчил арилахгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Хууль тогтоомжийн хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг эдийн засгийн аргаар зохицуулах боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Боловсролын байгууллага, удирдлагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэснээр зарим талаар байгууллагын үйл ажиллагааг дэмжих хэдий ч зорилгыг хангаж чадахгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Боловсролын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг баталж тодорхой асуудлыг шийдвэрлэж болох хэдий ч хууль хоорондын уялдааг хангаж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй	Тодорхой үр дүнд хүрэхгүй
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Дээд ,ерөнхий боловсролын салбарын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Боловсролын удирдах ажилтан, багш нарын сургалт, семинар, хэлэлцүүлэг болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс

зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээг харгалзан Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 1-ийн 1, 2, 3, 4 дүгээр хүснэгтээс үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөлд хүний эрхийг хууль бусаар хязгаарлах, ялгаварлах, гадуурхах зэрэг хүний эрхийн зөрчлийг агуулаагүй. Харин хуулийн төсөлд хүүхдийн хөгжил, төлөвшилд дэмжлэг үзүүлж ажилладаг зарим багш, ажилтны нийгмийн баталгаанд байгаа тэгш бус байдлыг арилгах, дотуур байранд амьдарч байгаа бага ангийн хүүхдийн сурах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, өсвөр насны хүүхдийг ойлгох, сэтгэл зүйн хямрал, гутрал, тогтворгүй байдлыг даван туулахад чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг ерөнхий боловсролын сургуульд нэвтрүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг тусгах замаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахад эерэг нөлөө үзүүлнэ. 6 дугаар хувилбар болох хууль тогтоомжийн төсөл боловсруулснаар гадаадад суралцан төгсөгчийн эх орондоо ажиллах нөхцөл бололцоог нэмэгдүүлнэ, ажил олгогч иргэн, байгууллага нь их дээд сургуулийн удирдах зөвлөл оролцох, дэмжих эерэг үр дагавар үүснэ.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн нэгэн адил боловсролын үйлчилгээ үзүүлдэг зарим багш, ажилтны нийгмийн баталгаа /ээлжийн амралт, тэтгэвэр, тэтгэмж гэх мэт/-ны тэгш бус байдлыг арилгаж, багш нарт адил тэгш хандах, хүүхдийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зарим орон тоог ерөнхий боловсролын сургуульд бий болгоход эдийн засагт ачаалал үүснэ. Хувилбар 6 буюу Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосноор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, их, дээд сургууль, коллежууд олгох улсын төсөв тодорхой хэмжээгээр өсгөх замаар төсвөөс зарцуулсан хөрөнгө нь ирээдүйд чадварлаг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, ажиллах боломжтой хүний нөөц бэлтгэгдэж, тэднээс дэлхийн зах зээлээс оруулах санаа, шийдэл, хөрөнгө оруулалт зэргээр Монгол Улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Бүх хувилбарууд нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ. Үүнээс: Хувилбар 2-5-ыг хэрэгжүүлснээр богино хугацаанд дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгаа сайжрах үр нөлөөтэй. Гэвч эрх зүйн баталгаатай орчин бий болоогүй учраас урт хугацааны бодлого төлөвлөлтгүй байдлаас болж суралцагчдын

мэдлэг чадвар, цаашлаад хөдөлмөрийн зах зээл, улс орны хөгжил дэвшил удаашрах магадлалтай.

Хувилбар 6-ыг хэрэгжүүлснээр дээд боловсролын сургалтын байгууллага хөдөлмөрийн зах зээлд дотоодод төгссөн суралцагчдын үнэлэмж, эрэлт хэрэгцээ нэмэгдэнэ. Боловсролын салбарын хөгжилд зориулагдан олгох санхүүжилтийг боловсронгуй болгож өрхийн амьжиргааны түвшин дээшилж нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.

Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжид эергээр нөлөөлнө. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирч зохицуулалт тодорхой, иргэдэд ойлгомжтой болно.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэг шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2. дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, мөн хуулийн 14.7 дахь хэсэгт “сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно” гэж, Монгол Улс 1964 онд нэгдэн орсон “*Боловсролын салбарт ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх тухай конвенц* /ЮНЕСКО, 1960/-ийн Хоёрдугаар зүйлд “Хэрэв боловсролын тухайн тогтолцоонд хамрагдах буюу тухайн байгууллагад суралцах нь сайн дурын байхын хамт олгож буй боловсрол, ялангуяа ижил түвшний боловсрол олгох тухайд эрх бүхий байгууллагын тогтоосон буюу баталсан тийм түвшинд нийцэж байгаа нөхцөлд сурагчдын эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчдын хүсэлтийн дагуу боловсролын тусгай тогтолцоо болон сургалтын байгууллагуудыг шашин, хэлний чиглэлээр байгуулан ажиллуулж болно”, Гуравдугаар зүйлд “боловсролын салбарт ялгаварлан гадуурхах явдлыг буй болгож байгаа эрх зүйн актууд болон захиргааны заавар, журмыг хүчингүй болгох, захиргааны тийм үйл ажиллагааг таслан зогсоох”, Дөрөвдүгээр зүйлд энэхүү конвенцод оролцогч улсууд нь боловсролын хэрэгт адил тэгш боломж олгох, адил тэгш хандах явдлыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн төрийн бодлогыг тухайн нөхцөл байдал болон үндэсний онцлогт нийцсэн аргаар боловсруулж, улам бүр боловсронгуй болгон хэрэгжүүлж байх ёстой” гэж, мөн 1974 онд нэгдэн орсон *Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт /1966/-д* “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Боловсрол хүний хувийн зан чанарыг бүхэлд нь бүрэн хөгжүүлэх, нэр төрөө ухамсарлахад чиглэгдэж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэн бэхжүүлэх ёстойг зөвшөөрч байна. Боловсрол хүн бүрт чөлөөт нийгмийн тустай гишүүн байх, бүх үндэстэн, арьс үндэстэн, угсаа, шашин шүтлэгээрээ ялгавар бүхий бүлгийн хувьд харилцан ойлголцох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахих талаар явуулж байгаа үйл ажиллагаанд дөхөм үзүүлэхэд бүгдэд боломж олгох ёстойг зөвшөөрч байна. Энэхүү Пактад оролцогч улсууд эцэг эх болон зохих нөхцөлд хууль ёсны асран хамгаалагчаас хүүхдэдээ төрийн байгууллагаас байгуулсан сургууль төдийгүй, боловсрол олгох талаар улсаас тогтоосон буюу баталсан наад захын шаардлагыг хангаж байгаа бусад сургуулийг сонгох, өөрийн хувийн итгэл, үнэмшлийн дагуу шашин шүтлэг болон ёс суртахууны боловсрол олгох боломжийг хангана. гэж тус

тус заасан байх тул хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь Үндсэн хууль болон Монгол Улс нэгдэн орсон хүний эрхийн олон улсын конвенц, пактийн агуулга, үзэл баримтлалтай нийцэж байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хуулийн төсөлд тусгах хувилбаруудын эерэг болон сөрөг талууд, зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзлээ.

Аргачлалын 7-д зааснаар хуулийн төсөлд тусгах хувилбаруудын эерэг болон сөрөг талууд, зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзлээ.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хуулийн төслөөр зохицуулах харилцаатай холбогдуулан хийгдсэн судалгааны мэдээлэлд үндэслэн зарим асуудлыг тодруулах зорилгоор НҮБ-аас баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго 2030”, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос гаргасан “Тэгш хамруулсан боловсрол эзэмших эрхийн талаарх зөвлөмж” болон ОХУ-ын боловсролын харилцааны эрх зүйн зохицуулалтыг тус тус сонголоо.

“Эх дэлхийгээ эрс шинэчилье: Тогтвортой хөгжлийн зорилго 2030”⁴

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар 2015 онд баталсан “Эх дэлхийгээ эрс шинэчилье: Тогтвортой хөгжлийн зорилго 2030” баримт бичигт дэлхий нийтийн ирэх 15 жилийн боловсролын хөгжлийн зорилт нь “*бүх түвшинд тэгш хамран сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол олгох, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих*” гэж байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд дараах стратегийг баримтлахыг улс орнуудад зөвлөжээ:

- Тэгш хамран сургах, тэгш боломж бүхий төрөөс санхүүжсэн 12 жилийн чанартай бага, дунд боловсролыг үнэ төлбөргүй олгох, үүнээс есөн жил нь заавал байхаар хууль тогтоомж, бодлого боловсруулж хэрэгжүүлэх ёстой;

⁴ Transforming world: The 2030 agenda for Sustainable development, United Nations

- Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, тэдгээрийг тухайн улс орны чадвар, чадамж, үнэт зүйлс, мэдлэг, соёл, жендерийн харьцаанд нийцүүлэн шинэчлэх;
- Сургуулийн удирдлагын бүтцэд эцэг, эх, олон нийт, залуу үеийн төлөөллийн оролцоог ханган сургуулийн засаглал, удирдлагыг бэхжүүлж, байгууллагын үр ашиг, өгөөжийг сайжруулах;
- Нийгэм-эдийн засгийн хувьд давуу болон эмзэг нөхцөл байдлаас хамаарч сургуулиудад нөөц хөрөнгийг тэгш байдлаар хуваарилах;
- Олон хэлний боловсролын орчинд хоёр ба олон хэлний боловсролын үйлчилгээгээр хангах замаар сурагчдад бага наснаас нь төрөлх хэлээрээ суралцах боломжоор хангах, дэмжих;
- Бага, суурь боловсролын насны сургуулийн гадна байгаа хүүхэд, залууст зориулсан хувилбарт сургалтын загвар нэвтрүүлэх, төрөөс батламжилсан, магадлан итгэмжилсэн дүйцүүлэх сургалтын хөтөлбөрийг албан, албан бус боловсрол болон онцгой байдлын үед уян хатан сургалтын хэлбэрээр явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэх;
- Төрсөн цагаасаа эхлэн бүх нийтийн насан туршдаа суралцах эрхийг олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээнд байгууллагын стратеги, бодлого, хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх хангамж нөөц бололцоог боловсролын тогтолцоонд бүрэн тусгасан байх;
- Жендер, хөгжлийн бэрхшээлд анхаарсан олон талт цогц бодлого хэрэгжүүлэх, сургуулийн орчинд аюулгүй, хүчирхийллээс ангид байх нөхцөлийг хангах хэм хэмжээ, тогтолцоог дэмжих;
- Багшийг ажилд авах, сургах, ажиллуулах, цалин хөлс олгох, ажлын нөхцөл сайжруулах, албан тушаал ахиулах боломжоор бүрэн хангасан, тэгш хамарсан, хүртээмжтэй, жендерийн мэдрэмжтэй багшийн удирдлагын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, багш, сурган хүмүүжүүлэгчийн нийгэмд эзлэх байр суурь, үр чадварыг сайжруулах.

Боловсролын салбарын хуулийг шинэчлэх ажлын хүрээнд ОХУ, БНСУ, Япон, Швед, Финлянд, Канад, Сингапурын боловсролын хууль тогтоомжийг 10 агуулгын хүрээнд харьцуулан судалсан. Энэхүү судалгааг олон улсын болон дотоодын зөвлөхүүдээр хийлгэсэн бөгөөд зөвлөмжийг хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулахад ашиглаж байна. Тухайлбал, ОХУ-ын Боловсролын тухай хууль⁵ “боловсролын хөтөлбөр” гэсэн бие даасан бүлэг (бүлэг 2)-тэй бөгөөд сургалтын хөтөлбөр нь боловсролын түвшин бүрээр байхаас гадна ерөнхий хөгжлийн болон мэргэжлийн бэлтгэлийн нэмэлт хөтөлбөртэй байна. Сургалтын хөтөлбөртэй холбогдуулан дараах асуудлыг хуульчилсан байна:

1. Боловсролын стандарт, хөтөлбөрт тавигдах шаардлагад (i) стандарт, хөтөлбөрийн бүтэц, хамрах хүрээ, (ii) хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах боловсон хүчин, санхүү, техникийн болон бусад нөхцөлийг тооцсон байх, (iii) сургалтын хөтөлбөрийг эзэмшсэний үр дүн зэргийг тусгасан байх бөгөөд

⁵ **Федеральный закон "Об образовании в Российской Федерации"**

боловсролын стандарт, хөтөлбөрийг батлах, түүнд оруулах өөрчлөлтийг ОХУ-ын Засгийн газар тогтоох;

2. сургалтын жишиг хөтөлбөрийг туршилт, шинжээчийн дүгнэлтэд үндэслэн хэрэгжүүлэх, туршилтын үйл ажиллагаа нь боловсролын шинэ технологи, нөөцийг хөгжүүлэх, турших, хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд туршилтын зохион байгуулалт, нөхцөлийг ОХУ-ын Засгийн газар тогтоох;
3. сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд алсын зайны технологи, цахим сургалт зэрэг боловсролын технологи ашиглах.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хичээллэх хугацаанд нь ОХУ-ын хууль тогтоомжид заасны дагуу нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчуулах (40 дүгээр зүйл), цэргийн албан хаагчдын халааг бэлтгэх зорилгоор цэргийн дунд сургууль (Ерөнхийлөгчийн цэргийн сургууль, Суворовын цэргийн сургууль, Нахимовын тэнгисийн цэргийн сургууль, кадетын сургууль /далайн/ болон тусгай зориулалт бүхий мэргэжлийн боловсролын байгууллага болох цэргийн хөгжмийн сургуультай байх бөгөөд нь эдгээр сургууль нь суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт интеграци хийсэн тусгай хөтөлбөртэй байна.

Хөдөө, тосгонд үйл ажиллагаа эрхэлж байгаа ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудад улсын болон орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт нь суралцагчдын тооноос үл хамаарахаар байна.(99 дүгээр зүйл).

Эрч хурдацтай өөрчлөгдөж байгаа өнөөгийн нийгэмд дээд боловсролын салбарыг дэлхийн нийтлэг жишигт хүргэх нийгмийн захиалгыг үндэслэн Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /хуучнаар /хамтран ажлын хэсэг байгуулан судалгаа хийсэн.

Өнөөдөр дэлхий дахинаа **авьяас, ур чадвар, бүтээлч сэтгэлгээний өрсөлдөөн** хүчтэй газар авч эхэлжээ.

2018 онд Дэлхийн Банкнаас гаргасан “Суралцахуй”⁶ гэсэн тайланд "...дэлхий дахинаа боловсролын системд өөрчлөлт хийж, багшлахаас илүүтэйгээр суралцахуйд түлхүү анхаарч, сурах үйл ажиллагааг дэмжих, сурах орчныг сайжруулах, сурах үйл явцын талаар их өгөгдлийн сан бий болгох замаар сургалтын чанарыг эрс дээшлүүлэх боломж бий болно" гэсэн дүгнэлт хийсэн байна.

Судалгаанаас үзэхэд Дэлхий дахинаа дээд боловсролын салбар нь өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх зэрэг томоохон асуудалтай тулгарч байна. Ийм нөхцөлд зах зээлийн жам ёсоор их, дээд сургуулиудын чансаа тогтоож, эрэмбэлэх тухайлбал, Shanghai Ranking Consultancy компанийн Дэлхийн их сургуулиудын академик эрэмбэ тогтоох (ARWU), Times Higher Education сэтгүүлийн (THE), Quacquarelli Symonds компанийн (QS) зэрэг олон янзын хөтөлбөрүүд бий болж, дэлхийн шилдэг их сургуулиудыг тодруулж шалгаруулдаг болжээ.

Нөгөө талаас, дэлхийн улс орнууд их дээд сургуулиудынхаа чанар, чансааг дээшлүүлэхийн тулд “Дэлхийн хэмжээний их сургууль” байгуулах талаар дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Дэлхийн хэмжээний их сургуультай болох төрийн

⁶ Learning: to realize education’s promise. World Development report. A World bank Group Flagship Report. 2018.

бодлогоо улс орон бүр өөр өөрийн нөхцөл байдалд тохирсон арга замаар хэрэгжүүлж байна. Дэлхийн дийлэнх улс оронд “том байх тусмаа илүү сайн үр дүнтэй” гэсэн итгэл үнэмшилд хөтлөгдөн их, дээд сургуулиудаа нэгтгэх үйл явц ерээд оны үеэс явагдаж эхэлсэн байна. Түүнээс гадна тэргүүлэх их сургуулиудаа төрийн бодлогоор дэмжих, тусгай хөтөлбөр хэрэгжүүлж санхүүжүүлэх зэрэг олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Дэлхийн түвшний судалгааны их сургуулийн гол үзүүлэлт нь:

- ✓ авьяасын төвлөрөл бий болгох,
- ✓ манлайллыг дээдэлж,
- ✓ их сургуулийн бие даасан байдлыг хангах,
- ✓ санхүүгийн харгалзах нөөцийг бүрдүүлэх явдал юм.

Олон жилээр үйл ажиллагаагаа явуулж өөрийгөө хэрхэн удирдахыг өөрөөс нь илүү мэддэг байгууллагагүй шахам болсон улс оронд бие даасан байдлын түвшин өндөр байдаг байна.

Үүний жишээнд Их Британий их сургуулиудыг дурдаж болно. Их сургуулийн бие даасан байдал нь түүнийг улстөржилд, бизнесийн явцуу эрх ашгаас хамгаалах, академи эрх чөлөөг нь хангах чухал нөхцөл юм.

Тиймээс дэлхийн ерөнхий хандлага бол их сургуулийн бие даасан байдлыг дээшлүүлэхэд чиглэж байна.

Үүний зэрэгцээ шинжлэх ухаан, технологи улс орны хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлж буй, үүний улмаас төрөөс их сургуулиудыг санхүүжүүлэх хэмжээ өсөж байгаа, эцэг эхчүүд хүүхдийнхээ сургалтын төлбөрт хөрөнгө зарцуулж байгаа зэргээс үүдэн их сургуулийн төр, нийгмийн өмнө хүлээх үүрэг өндөржиж, төр нийгмийн өмнө тайлагнах, ил тод байх шаардлага гарч байгаа юм. Өөрөөр хэлбэл бие даасан байдал нь үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгааг төр нийгэмд эргэн тайлагнахтай нягт холбоотой гэсэн үг юм.

Их сургуулийн бие даасан байдал хэмээх нь хийсвэр ойлголт байж болохгүй юм. Ийм тохиолдолд түүнийг үнэлэхэд бэрхшээлтэй, улмаар энэ талын бодлого гаргахад хүндрэлтэй байдаг.

Тиймээс Дэлхийн банк, Европын Холбоо гэх мэт байгууллага болон судлаачид их сургуулийн бие даасан байдлыг тодорхой үзүүлэлтээр хэмжих оролдлого хийж, зарим санал дэвшүүлсэн байдаг.

Дэлхийн банкны судлаачид зүүн Азийн бага болон дунд орлоготой орнуудын дээд боловсролын байгууллагуудын талаар хийсэн судалгаандаа дараах үзүүлэлтүүдийг ашиглажээ.

Агуулгын буюу академи талын үзүүлэлтүүд	Дэгийн буюу академи бус шинжтэй үзүүлэлтүүд
Хөтөлбөрийн зохиомж	Төсөв
Эрдэм шинжилгээний бодлого	Санхүүгийн менежмент
Элсэлтийн стандарт	Сургалт судалгааны бус ажилтнуудын томилгоо

Сургалт, судалгааны ажилтнуудын томилгоо	Худалдан авалт
Зэрэг олгох	Гэрээ хэлцэлд оролцох

Улс орнуудын их сургуулийн бие даасан байдал янз бүрийн төвшинд байгаа нь тухайн орны улс төрийн систем болон бусад онцлогоос хамааралтай. Нийт судлагдсан 12 орноос хоёрт нь элсэлтийн тоог сургууль өөрөө тогтоох, гуравт нь байшин, тоног төхөөрөмжөө өмчлөх, гуравт нь сургалтын төлбөрөө тогтоох бүрэн эрхтэй байдаг байна.

Элсэлтийн тоо нь хүний нөөцийн бодлоготой, сургалтын төлбөр нь хүн амын амьдралын төвшин, улс төрийн асуудалтай холбогддог учраас ихэнх орон сургуульд бүрэн эрх өгөхөөс болгоомжилдог байж болох юм.

Сургуулиуд харьцангуй их эрх эдэлдэг асуудлууд бол сургуулийн бүтэц, хичээлийн агуулгыг тодорхойлох, ажилтнуудыг ажилд авах болон халах, төсвөө захиран зарцуулах асуудлууд байна. Европын Холбооны Их сургуулиудын Ассоциациас бүр ч дэлгэрэнгүй үзүүлэлт гаргаж тус тивийн 29 орны их сургуулиудын бие даасан байдлыг үнэлсэн байна.

Зохион байгуулалтын бие даасан байдал

Удирдах зөвлөл дэх гаднын гишүүд

	Зохицуулалт	Улсын нэр
1	Сургууль гаднын гишүүд оруулахгүй хэмээн шийдэх эрхгүй 3 улс	Бранденбург, Латви, Польш
2	Сургууль гаднын гишүүн оруулна гэж шийдэх эрхгүй 24 орон	Австри, Хорват, Дани, Финлянд, Фландер, Франц, Валлони, Гэссен, Унгар, Исланд, Ирланд, Итали, Литва, Люксембург, Нидерланд, Умарт Рейн-Вестфали, Норвег, Португал, Серб, Словак, Словени, Испани, Швед, Швейцар
3	Сургууль гаднын гишүүн оруулахыг шийдэх эрхтэй 2 орон	Эстони, Англи
4	Сургууль гаднын гишүүн оруулах асуудлыг чөлөөтэй шийдэх эрхтэй 7 улс	Дани, Эстони, Финлянд, Итали, Литва, Португал, Англи
5	Гаднын гишүүдийг сургууль өөрөө санал болгож гаднын байгууллага томилдог 3 улс	Норвег, Словак, Швед
6	Гаднын гишүүдийн хагасыг сургууль, хагасыг нь гаднын байгууллага томилдог 7 улс	Австри, Хорват, Франц, Валлони, Гэссен, Исланд, Словени
7	Томилгоог бүхэлд нь гаднын байгууллага мэддэг 6 улс	Унгар, Люксембург, Нидерланд, Серб, Испани, Швейцар
8	Томилгооны өөр журамтай 3 улс	Фландер, Ирланд, Умарт Рейн-Вестфали

Академи бүтцийн асуудлыг шийдэх чадвар

	Зохицуулалт	Улсын нэр
1	Ямар нэг хязгаарлалтгүй сургууль өөрөө шийдэх эрхтэй 20 улс	Австри, Бранденбург, дани, Эстони, Финлянд, Фландер, Валлони, Гессен, Унгар, Латви, Литва, Нидерланд, Умарт Рейн-Вестфали, Норвег, Польш, Португал, Испани, Швед, Швейцар, Англи
2	Хуулиар зохицуулдаг 4 улс	Франц, Исланд, Итали, Серб
3	Гаднын байгууллага хуульд заасан журмаар батламжилдаг 6 улс	Бранденбург, Исланд, Латви, Люксембург, Словак,
4	Факультет болон бусад академи бүтцийг хуульд жагсаасан байдаг 4 улс	Хорват, Люксембург, Словак, Словени
5	Бусад зохицуулалттай 2 улс	Ирланд, Серб

Хуулийн этгээд байгуулах чадвар

	Зохицуулалт	Улсын нэр
1	Хуулийн этгээд байгуулах бүрэн эрхтэй 19 улс	Австри, Бранденбург, Хорват, Эстони, Финлянд, Фландер, Франц, Валлони, Гессен, Унгар, Итали, Литва, Люксембург, Нидерланд, Умарт Рейн-Вестфали, Норвег, Серб, Испани, Англи
2	Сургууль зөвхөн ашгийн бус хуулийн этгээд байгуулах эрхтэй 2 улс	Словени, Швейцар
3	Ямар ч хуулийн этгээд байгуулах эрх өгөөгүй	Байхгүй
4	Бусад зохицуулалт бүхий 8 улс	Дани, Исланд, Ирланд, Латви, Польш, Португал, Словак, Швед

Академи асуудлын хүрээний бие даасан байдал

Бакалаврын түвшинд хөтөлбөр нээх

	Зохицуулалт	Улсын нэр
1	Сургууль урьдчилсан аккредитацгүйгээр өөрөө нээх эрхтэй 8 улс	Австри, Ирланд, Люксембург, Норвег, Польш, Швед, Швейцар, Их Британи

2	Санхүүжилт авах бүх шинэ хөтөлбөр эхлээд магадлан итгэмжлэгдэх ёстой 4 улс	Хорват, Франц, Нидерланд, Испани
3	Бүх шинэ хөтөлбөр эхлээд магадлан итгэмжлэгдэх ёстой 10 улс	Фландер, Валлони, Унгар, Итали, Литва, Умард Рейн-Вестфали, Португал, Серб, Словак, Словени
4	Бусад зохицуулалт бүхий 10 улс	Австри, Бранденбург, Дани, Эстони, Финланд, Фландер, Гессен, Исланд, Латви, Швед

Магистрын хөтөлбөр нээх

	Зохицуулалт	Улсын нэр
1	Сургууль урьдчилсан магадлан итгэмжлэлгүйгээр нээх эрхтэй 8 улс	Австри, Ирланд, Люксембург, Норвег, Польш, Швед, Швейцар, Их Британи
2	Санхүүжилт авах бүх шинэ хөтөлбөр эхлээд магадлан итгэмжлэгдэх ёстой 4 улс	Хорват, Франц, Нидерланд, Испани
3	Бүх шинэ хөтөлбөр эхлээд магадлан итгэмжлэгдэх ёстой 10 улс	Фландер, Валлони, Унгар, Итали, Литва, Умард Рейн-Вестфали, Португал, Серб, Словак, Словени
4	Бусад зохицуулалт бүхий 10 улс	Австри, Бранденбург, Дани, Эстони, Финланд, Фландер, Гессен, Исланд, Латви, Швед

Докторын сургалтын хөтөлбөр нээх

	Зохицуулалт	Улсын нэр
1	Сургууль урьдчилсан магадлан итгэмжлэлгүйгээр нээх эрхтэй 13 улс	Австри, Бранденбург, Дани, Фландер, Гессен, Ирланд, Люксембург, Нидерланд, Умард Рейн-Вестфали, Норвег, Швед, Швейцар, Их Британи
2	Санхүүжилт авах бүх шинэ хөтөлбөр эхлээд магадлан итгэмжлэгдэх ёстой улс	Байхгүй
3	Зөвхөн зарим сургууль болон Академийн нэгж шинэ хөтөлбөр нээх эрхтэй 1 улс	Литва
4	Бүх шинэ хөтөлбөр эхлээд магадлан итгэмжлэгдэх ёстой 10 улс	Хорват, Франц, Валлони, Унгар, Итали, Португал, Серб, Словак, Словени, Испани
5	Бусад зохицуулалт бүхий 8 улс	Австри, Эстони, Финланд, Фландер, Исланд, Латви, Польш, Швед

Зэрэг олгох хөтөлбөрийг зогсоох

	Зохицуулалт	Улсын нэр
--	-------------	-----------

1	Сургууль өөрөө зогсоох эрхтэй 26 улс	Хорват, Дани, Эстони, Фландер, Франц, Валлони, Гессен, Унгар, Исланд, Ирланд, Итали, Латви, Литва, Люксембург, Нидерланд, Умард Рейн-Вестфали, Норвег, Польш, Португал, Серб, Словак, Словени, Испани, Швед, Швейцар, Их Британи
2	Сургууль гаднын байгууллагатай хэлэлцэн шийдвэрлэдэг 3 улс	Австри, Бранденбург, Финлянд

Чанарын баталгаажилтын механизм

	Зохицуулалт	Улсын нэр
1	Сургууль хэрэгцээндээ нийцүүлэн холбогдох механизмыг өөрөө сонгодог 3 улс	Бранденбург, Гессен, Умард Рейн-Вестфали
2	Сургууль өөрөө сонгох эрхгүй 26 улс	Австри, Хорват, Дани, Эстони, Финлянд, Фландер, Франц, Валлони, Унгар, Исланд, Ирланд, Итали, Латви, Литва, Люксембург, Нидерланд, Норвег, Польш, Португал, Серб, Словак, Словени, Испани, Швед, Швейцар, Их Британи

Чанарын баталгаажилтын байгууллагыг сонгох

	Зохицуулалт	Улсын нэр
1	Сургууль хэрэгцээндээ нийцүүлэн өөрөө сонгодог /үүний дотор гадаадын байгууллагыг/ 8 улс	Австри, Бранденбург, Эстони, Финлянд, Гессен, Унгар, Умард Рейн-Вестфали, Швейцар
2	Сургууль өөрөө сонгох эрхгүй 21 улс	Хорват, Дани, Фландер, Франц, Валлони, Исланд, Ирланд, Итали, Латви, Литва, Люксембург, Нидерланд, Норвег, Польш, Португал, Серб, Словак, Словени, Испани, Швед, Швейцар, Их Британи

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухайн конвенцын Тэгш хамруулсан боловсрол эзэмших эрхийн тухай зөвлөмж 4 (2016.11.25)⁷

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод чанартай тэгш хамруулсан боловсролын тухай ойлголтыг оруулснаар заавал биелүүлэх шинжтэй олон улсын гэрээгээр баталгаажуулсан анхны тохиолдол бөгөөд энэхүү ойлголтыг хэрэгжүүлэх үүднээс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос 2016 оны 11 дүгээр сард “Тэгш хамруулсан боловсрол эзэмших эрхийн талаар ерөнхий зөвлөмж”-ийг улс орнуудад өгсөн байна. Энэхүү зөвлөмжөөр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг улс орнуудад уриалсан байна:

1. Тэгш хамруулсан боловсрол эзэмших эрхийг дордуулж байгаа ялгаварлан гадуурхсан хууль зүйн, захиргааны, бусад бүх хэлбэрийг арилгах алхмыг яаралтай хийх. Тухайлбал, “боловсрол олгох боломжгүй” гэж зарим суралцагчдыг ангилсан заалт

⁷ General comment No 4 (2016) on the right to inclusive education, Committee on the Rights of Persons with Disabilities, Convention on the Rights of Persons with Disabilities

байвал шууд халах ёстой. Иймээс тэгш хамруулсан боловсролд үр нөлөө үзүүлэх боломжтойг баталгаажуулж, тэгш хамруулах нь бодит зорилго гэдгийг ойлгомжтойгоор бүх хууль тогтоомждоо заах;

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн амьдран суугаа газартаа бага, дунд сургуульд элсэх боломжтой байх ёстой. Суралцагчдыг гэрээс нь холдуулж болохгүй. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын бусад суралцагчидтай ах/эгч, дүү нартайгаа идэвхтэй харилцах, оролцох нь тэгш хамруулсан боловсрол эзэмших эрхийн чухал хэсэг байх;

3. Суралцагч бүрт шаардлагатай туслах нэмэлт хэрэгсэл, хувилбарт, хүртээмжтэй хэлбэртэй сургалтын тусгай материал, харилцааны хэрэгсэл, өөр бусад хэв маяг, туслах хэрэгсэл, мэдээллийн болон туслах технологи зэрэг тохирох хэрэглэгдэхүүн, тусгай дэмжлэгийг багтаасан сургалтын ганцаарчилсан төлөвлөгөөг боловсруулах хэрэгцээг онцлон анхаарах. Иймээс суралцах тусгай шаардлагад нийцсэн сургалтын ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулах, ашиглахыг улс орнуудад анхааруулж байна. Сургалтын ганцаарчилсан төлөвлөгөө нь тусгаарласан орчноос ердийн сургалтын байгууллага руу, мөн боловсролын шат түвшний хооронд шилжих шилжилтийг тусгаж шийдвэрлэх ёстой;

4. Тэгш хамруулсан суралцагчийн үнэлгээний тогтолцоо ганцаарчилсан дэмжлэгийн тогтолцоогоор улам сайжруулах;

5. Нийгмийн харилцааны хувьд бэрхшээлтэй суралцагчдад хосоор ажиллах, үе тэнгийнхэн харилцан дэмжих, багшдаа ойр суух, хэсэгчлэн төлөвлөсөн болон урьдчилан таамаглахуйц орчныг бий болгох зэргээр ангийн зохион байгуулалтыг өөрчлөх замаар дэмжлэг үзүүлэх;

6. Тэгш хамруулсан боловсрол нь тусгаарлах байгууламжтай зохицохгүй. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгаарлах байгууламжийг байхгүй болгох үйл явцыг үе шаттайгаар сайтар төлөвлөж хийх ёстой.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Боловсролын тухай хуулиар дараах асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна:

- Боловсролын хууль нэгдмэл байх зарчим баримтлах. Энэхүү зарчмын хүрээнд Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, нийгмийн баталгааны тухай хууль, Багшийн хөгжлийн тухай хуулийг нэгтгэн “Боловсролын тухай” хуулийн төсөл боловсруулна.

- Хуулийн зорилт болон боловсролын зорилго, үндсэн зарчимд дэлхий нийтийн боловсролын хөгжлийн чиг хандлага болон тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгах.

- Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний агуулга, бүтцийг зөвхөн боловсролын хуулиар зохицуулж байхаар тусгах.

- Хуульд тусгагдаагүй болон нарийвчлан зохицуулах шаардлагатай зарим нэр томъёог нэмж тусгах.

- Төрөөс боловсролын талаар үзүүлж буй зарим үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор боловсролын удирдлагын тогтолцоонд орон нутгийн эрх барих байгууллагын эрх мэдлийг оновчтой тодорхойлох, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар орон нутагт зарим чиг үүргийг бүрэн хариуцуулах.

- Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуульд хамрагдах насыг дэлхий нийтийн чиг хандлага, малчдын ахуй амьдралтай уялдуулан уян хатан байлгах нөхцөлөөр өөрчлөх.

- Бага, дунд боловсролын сургалтын бодлого, агуулга, үндэсний хөтөлбөр, сурах бичгийн тогтвортой байдал, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурч боловсрох эрхийг тэгш хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хаана амьдарч байгаагаас үл хамаарч боловсролын үйлчилгээ авах адил тэгш нөхцөл боломж бүрдүүлэх зохицуулалтыг нарийвчлан тусгах.

- Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн ангилал, хэв шинжийг өөрчлөх.

- Сургууль бүр өөрийн онцлог, нөхцөл бололцоонд зохицон бие даан хөгжих эрхийг өргөжүүлэх, суралцагчийн сурч боловсрох эрхийг тэгш хангах, сургууль, эцэг, эх, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, боловсролын байгууллагын орчин дахь аюулгүй байдлыг хангахтай холбогдох харилцааг хуульд нарийвчлан зохицуулах.

- Боловсрол эзэмших хэлбэр /өдөр, орой, зайн сургалт, нээлттэй боловсрол/-ийг тодорхой зохицуулж, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих зохицуулалтыг тусгах.

- Боловсролын сургалтын байгууллагын засаглалыг боловсронгуй болгох, удирдах албан тушаалд томилогдох шалгуурт мэргэшсэн, мерит зарчмыг баримтлах зохицуулалтыг тусгах.

- Эх оронч сэтгэлгээ, үндэсний аюулгүй байдлын үнэт зүйлсийг шингээсэн, эх орноороо бахархах үзэл, хүмүүжил төлөвшүүлэх, эх орноо батлан хамгаалах залуу үеийг бэлтгэхэд дэмжлэг болох төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийг цэргийн дээд боловсрол эзэмшүүлэх төрийн өмчийн сургалтын байгууллагын харьяанд байгуулах, тухайн сургууль бага боловсрол эзэмшсэн иргэнийг элсүүлж суурь, бүрэн дунд боловсрол олгодог байхаар зохицуулалт хийх.

- Нийтийн тээврийн үйлчилгээ хөгжсөн хот, суурин газрын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хичээлийн жилийн хугацаанд сургуульдаа ирэх, буцахад нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих зохицуулалтыг бий болгох

- Боловсролын сургалтын чанарыг сайжруулах, мэргэшсэн, ёс зүйтэй, чадварлаг багш бүхий хүний нөөц бүрдүүлэх зорилгоор цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг аттестатчилах асуудлыг судлан хуульчлах.

- Эцэг эх асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг сайжруулах зорилгоор хуульд нарийвчилсан зохицуулалтыг тусгах.

- Цэцэрлэг, сургуулийн хэмжээ, байршлаас хамааруулан түүнд ажиллах албан тушаалыг тогтоох, орон тооны нормативыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Сангийн болон Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайдтай хамтарч батлахаар зохицуулах.

- Хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг төрөөс санхүүжүүлж байгаа зохицуулалтыг өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй

суралцагчийг суралцуулж байгаа тохиолдолд тухайн сургуульд хүүхдийн тооноос хамаарч нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дэмжлэгийг төрөөс үзүүлдэг байхаар зохицуулалт хийх.

- Хүүхэд өөрт тулгамдсан асуудлаа зохистойгоор шийдвэрлэж, ганцаардал, сэтгэл гутралыг даван туулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх сургуулийн сэтгэл зүйчтэй байх зохицуулалтыг тусгах.

- Олон улс болон хөгжингүй орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг ерөнхий боловсролын хөтөлбөрийн шалгалтын оноог зөвшөөрч /элсэлтийн ерөнхий шалгалт/, харилцан тооцох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэхээр зохицуулах.

- Боловсролын эрдэм шинжилгээ, судалгаа, үнэлгээ, багшийн мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролын асуудал хариуцсан байгууллагын чиг үүрэг, бүтэц, хэв шинжид өөрчлөлт оруулах.

- Албан бус боловсрол, насан туршийн боловсролын агуулга, чиг хандлагыг дэлхийн боловсролын чиг хандлагатай нийцүүлэн өөрчлөх, удирдлага, мэргэжлийн хүний нөөц бэлтгэх, албан тушаалын статусыг оновчтой нэршлээр нэрлэн, зохих нийгмийн баталгааг хангах зохицуулалт хийх.

- Албан, албан бус боловсрол эсхүл албан бус суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвараар тодорхойлогддог чанарын баталгаа бүхий мэргэшлүүдийг логик уялдаатай, дараалан тогтоосон түвшний дагуу ангилж, нэгдсэн тогтолцоонд оруулдаг “Мэргэшлийн үндэсний хүрээ”-г боловсролын болон Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар зохицуулах.

- Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааг төрөөс хараат бус, мэргэжлийн, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц, бие даан шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалтыг тусгах.

- Дээд боловсролын сургалтын байгууллагын хэв шинж, ангиллыг боловсронгуй болгох, энэ чиглэлийн журмыг Засгийн газар баталдаг байхаар хуульчилж, Судалгааны сургуулийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох.

- Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлд ажил олгогч, мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллагын төлөөлөл, бизнес хөрөнгө оруулагчдын төлөөллийг нэмэгдүүлэх, Удирдах зөвлөл дэх төрийн төлөөллийн зохистой хувь хэмжээг тогтоох, Удирдах зөвлөлийн чиг үүргийг нарийвчлан зохицуулах.

- Дээд боловсролын хөгжлийн түвшин, төрийн бодлого, тэргүүлэх чиглэл, мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх төслүүдийн санал, олон улсын конвенцод нэгдэх бодлого, их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх бодлого, шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлоготой уялдуулах чиг үүрэг бүхий Дээд боловсролын үндэсний зөвлөл ажиллах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

- Боловсролын шаталсан тогтолцооны хүрээнд дунд мэргэжилтэн бэлтгэдэг политехник коллеж, коосен коллежийн хэв шинж, сургалтын хөтөлбөр, агуулга, чиг үүргийг нарийвчлан тодорхойлж хуульчлах.

- Боловсролын зээлийн санг Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт элсэгчид, их сургууль, дээд сургууль, коллежийн тэргүүлэх мэргэжлийн суралцагчдын сурлагын амжилт, чанартай уялдуулсан, онцгой амжилт

гаргасан тохиолдолд тэтгэлэг, тусламж, зээл олгодог, оюутны хөгжлийг дэмжих хэлбэрээр Дээд боловсролын хөгжлийн сан болгон өөрчлөх.

- Гадаад улсад боловсрол эзэмшүүлэх, сургалтад хамруулахад иргэдийг хохироохоос сэргийлэх, сургалтын байгууллага, үйл ажиллагааны чанартай байдлыг хангах, Монгол иргэний эрхийн асуудлыг хамгаалах зорилгоор зуучлах байгууллагад зөвшөөрөл олгох, бүртгэх журмыг Хууль зүйн болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталж, хяналт зохицуулалт хийхээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

- Боловсролын мэргэжлийн хяналтын тогтолцоо, чиг үүрэг, хариуцлагыг сайжруулж хуульчлах.

---oO---

1.ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Сурагчдын хөгжил, төлөвшилд багшийн адил үүрэг гүйцэтгэдэг зарим багш, ажилтны нийгмийн баталгаанд үүсэж байгаа ялгаатай байдлыг арилгах асуудлыг хуульчилна.
	Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Удирдах ажилтанд тодорхой шаардлага тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш.
	Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийн хэм хэмжээнд нийцнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Боловсролын байгууллагын багш, ажилтан, боловсролын асуудлаар үйл ажиллагаа эрхэлдэг иргэний нийгмийн байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэж хуулийн төслийг боловсруулна.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан болон холбогдох байгууллага, албан тушаалтнаас санал авна.
1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага				

	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн Үндсэн хуульд заасан эрх хангагдах баталгаа бүрдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын Хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хүн бүр тэгш эрхтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлнэ.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хуульд заасны дагуу тооцно.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Ямарваа нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	ЕБС-ийн орчинд суралцагч зохион байгуулалттайгаар хичээл хаялт зохион байгуулахыг хориглох хязгаарлалт нь нийтийн эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс зайлшгүй шаардлагатай.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Боловсролын харилцаанд оролцогч багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч болон боловсролын байгууллага
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөлд ялгаж тодорхойлох шаардлагагүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Ямарваа нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Эрх агуулагчдын ялангуяа, эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх/хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний	Тийм	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад тэгш боломж олгоно.

	цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/			
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах чиглэлээр боловсролын байгууллага, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч үүрэг хүлээнэ.
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийн ерөнхий зарчмын хүрээнд тусгагдана.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Бүх нөхцөлд жендерийн тэгш байдлыг хангах нөхцөл, агуулгаар тусгагдана.

2.ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж байгууллага болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллага хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх /эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан/	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгж байгууллагад бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
3.Аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгж, байгууллагад шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа, бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, хориг тавих эсэх	Тийм	Үгүй	сөрөг нөлөөгүй
	3.5.Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа зогсоох нөхцөл байдал бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэх захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал /мэдээлэх, тайлан гаргах г.м/ бий боллх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг /үл хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг г.м/ хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.3.Оюуны өмчийн /патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг/ эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Инноваци ба судалгаа, шинжилгээ	6.1.Судалгаа, шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.4.Хувь хүний болон гэр бүлийн санхүүгийн байдалд /шууд буюу урт хугацааны туршид/ нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төсвийн зардал нэмэгдүүлэх үр нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сум, дүүргийн Засаг даргад үүрэг бий болно.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг байдлаар зөрчилдөхгүй

3.НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
------------------	---------------------	---------	---------

1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.3.Тодорхой нэг ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдлыг үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх /эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнх г.м/	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Гадаадын иргэдэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Зарим чиг үүрэг, хариуцлага тодорхой болно.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, эрх бүхий байгууллагад гомдол гаргах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхүйц дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг /хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ г.м/-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч эерэг нөлөө гарна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.3. Боловсрол /төрийн болон хувийн хэвшлийн сургуулиар/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч эерэг нөлөө гарна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх			эерэг
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх			эерэг

	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

4. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.2.Эдийн засаг дахь эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	эерэг
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Ан, амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	эерэг
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.2.Хөрсийг эвдлэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Газар ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
7.Нөхөн сэргээгдэх /сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргэх чадавхыг нь алдагдуулахгүй зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

---oOo---